

**Дасгал-1.1.**Түүхэн зүтгэлтэн нэрлээрэй.



A. \_\_\_\_\_  
B. \_\_\_\_\_  
C. \_\_\_\_\_

1.2. Түүхэн зүтгэлтэн нь Монголын түүхийн ямар үед хамаарах эсэх хүснэгтэнд тулгуурлан өгөгдөлийг зөв нөхөөрэй.

| 1911-1924 он | 1924-1990 он | 1990 оноос эдүгээ |
|--------------|--------------|-------------------|
|              |              |                   |

**Дасгал-2.** Дараах үгийн утгыг тайлбарлан бичээрэй.

A.Түүхийн эх сурвалж \_\_\_\_\_

\_\_\_\_\_

B. Түүхийн сургамж \_\_\_\_\_

\_\_\_\_\_

**Дасгал-3.** Үндэсний дэвшилтэт ардчилсан сонин “Шинэ толь” хэмээх бичиг 1913 онд хэвлэгдсэн нь орчин үеийн Монголын түүхийн нэгэн эх сурвалж болсон. Аргын тооллын 1913 оныг билгийн тоололд шилжүүлээрэй.

Хүснэгт 1.3

| Махбодь жил | Гал | Шороо | Төмөр | Ус | Мод |
|-------------|-----|-------|-------|----|-----|
| Туулай      | 1   | 13    | 25    | 37 | 49  |
| Луу         | 50  | 2     | 14    | 26 | 38  |
| Могой       | 51  | 3     | 15    | 27 | 39  |
| Морь        | 40  | 52    | 4     | 16 | 28  |
| Хонь        | 41  | 53    | 5     | 17 | 29  |
| Бич         | 30  | 42    | 54    | 6  | 18  |
| Тахиа       | 31  | 43    | 55    | 7  | 19  |
| Нохой       | 20  | 32    | 44    | 56 | 8   |
| Гахай       | 21  | 33    | 45    | 57 | 9   |
| Хулгана     | 10  | 22    | 34    | 46 | 58  |
| Үхэр        | 11  | 23    | 35    | 47 | 59  |
| Баар        | 60  | 12    | 24    | 36 | 48  |

**Дасгал-4.** Баримтыг дараах асуултын дагуу шинжлээрэй. (Сурах бичиг хуудас-8)

| Баримт                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                     | Баримт                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                             |
|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <p>Суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөрийн зорилго нь сурагч бүрийг сурах арга барил, амьдрах ухаан, шинжлэх ухааны суурь мэдлэг, чадвар, бие даан бүтээлчээр суралцах чадвар эзэмших, үндэсний хэл, түүх, соёлоо дээдлэн хөгжүүлэх, ардчилсан, хүмүүнлэг үзэлтэй иргэн төлөвших боломж олгоход оршино.</p> <p><b>Эх сурвалж:</b> Монгол улсын Суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөрөөс авав. 2015 оны 7-р сар.</p> | <p>Байгалийн ухааны хичээлийг үзэж судлахад .. Бүтээх арга нь .... хамгийн үр дүнтэй арга..... Энэ арга нь шинжлэх ухааны болон байгалийн ухааны холбогдох хуулийг өөрийн биеэр мэдэрч судалж мэдэх.....Судлагдахууны агуулга болон өдөр тутмын амьдрал, нийгмийн амьдралын уялдаа холбоог илрүүлэх, мэдлэгээ ашиглаж сурахад хамгийн үр дүнтэй арга юм.</p> <p><b>Эх сурвалж:</b> Япон улсын Дунд сургуулийн Байгалийн ухааны сургалтын хөтөлбөрийн зөвлөмжөөс (3-р бүлгийн 1-ээс) товчлон авав.</p> <p>Хэйсэй 20 оны 9-р сар</p> |

1. Баримтууд ямар эх сурвалжуудад хамаарах вэ?

2.Баримт бүрийн агуулгыг тодорхойлоорой.

3.Ямар улсуудын аль салбарт хамаарах мэдээллийг өгч байна вэ?

